



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.07.31 № 256

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Говь-Алтай аймгийн Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
МОНГОЛ АРДЫН НАМД

0702 00846

## Дүгнэлт

Говь-Алтай аймгийн Монгол ардын намын Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Говь-Алтай аймгийн Монгол ардын намын мөрийн хөтөлбөр (...<sup>10</sup> хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Говь-Алтай аймгийн Монгол ардын намд

Хувийг: Говь-Алтай аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт ...<sup>10</sup> хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
МОНГОЛ АРДЫН НАМ

АЙМГИЙН ИТХ-ЫН 2024 ОНЫ 9 ДЭХ УДААГИЙН  
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ДЭВШҮҮЛСЭН

**“АЛТАЙН СЭРГЭЛТ”**

МӨРИЙН ХӨТӨЛБӨР  
(2024-2028)

2024 он

## АГУУЛГА

## НЭГ. БИДНИЙ АЛТАЙ

- 1.1 ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ ХОТ ТӨЛӨВЛӨЛТ
- 1.2 ЭРЧИМ ХҮЧНИЙ ХАНГАМЖ
- 1.3 ОРОН СУУЦНЫ ХАНГАМЖ
- 1.4 УСАН ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН ХАНГАМЖ

## ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ АЛТАЙ

- 2.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ
- 2.2 СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮРТЭЭМЖ
- 2.3 НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХҮРТЭЭМЖ
- 2.4 АВТО ЗАМЫН ХҮРТЭЭМЖ

## ГУРАВ. НОГООН АЛТАЙ

- 3.1 ХҮНСНИЙ ХАНГАМЖ, ЧАНАР АЮУЛГҮЙ БАЙДАЛ
- 3.2 ТОХИЖИЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖ
- 3.3 АГААР, ХӨРС, УСНЫ БОХИРДОЛ
- 3.4 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

## ДӨРӨВ. ОРЛОГОТОЙ АЛТАЙ

- 4.1 ШИНЭ ХОРШОО ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТ
- 4.2 ХУВИЙН ХЭВШЛИЙГ ДЭМЖИНЭ
- 4.3 ӨМЧИЙН ЗӨВ МЕНЕЖМЕНТ
- 4.4 СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

## ТАВ. АЮУЛГҮЙ АЛТАЙ

- 5.1 ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ОНОВЧТОЙ ТӨЛӨВЛӨЛТ
- 5.2 ИННОВАЦИ, ХИЙМЭЛ ОЮУН УХААН, ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ
- 5.3 ГАМШГИЙН БЭЛЭН БАЙДАЛ



**НЭГ. БИДНИЙ АЛТАЙ****1.1 ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ ХОТ ТӨЛӨВЛӨЛТ**

- 1.1.1 Говь-Алтай аймгийг 2025-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг иргэд, аж ахуйн нэгж байгууллагын санал, Монгол Улсын Хөгжлийн бодлого, Бүсчилсэн Хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан боловсруулж эрэмбэлж хэрэгжүүлнэ.
- 1.1.2 Алтай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тулгуурлан шинэ суурьшлын бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, сумдын ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад иргэдийн оролцох боломжийг бүрдүүлнэ.
- 1.1.3 Төсвийг төлөвлөх, хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах худалдаа үйлчилгээний чанар хүртээмж, соёлыг дээшлүүлэхэд хувийн хэвшил, иргэд, төрийн бус байгууллагын оролцоог бүрдүүлнэ.
- 1.1.4 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээ, түүний гүйцэтгэлд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 1.1.5 Төрийн нийтлэг үйлчилгээг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлж, тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлж, бизнес үйл ажиллагаанд төрийн оролцоог бууруулна.

**1.2 ЭРЧИМ ХҮЧНИЙ ХАНГАМЖ**

- 1.2.1 Хотын инженерийн дэд бүтцийг өргөтгөн ус, дулаан, эрчим хүчний найдвартай байдлыг хангуулна.
- 1.2.2 Аймгийн төвд 25 МВт-ын хүчин чадалтай дулааны станцыг ашиглалтад оруулна.
- 1.2.3 Алтай хотод Шинэ суурьшлын бүсүүдэд "Дулаан хуваарилах төвүүд"-ийг байгуулна.
- 1.2.4 Алтай хотын гэр хорооллын айл өрхийг 2 тарифт шөнийн тоолуур, энгийн тарифт тоолуур, ухаалаг тоолуурт бүрэн хамруулна.
- 1.2.5 Босоо тэнхлэгийн Мөрөн-Улиастай-Алтайн 220кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцуудыг барих ажлыг эхлүүлнэ.

**1.3 ОРОН СУУЦНЫ ХАНГАМЖ**

- 1.3.1 Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд аймаг, сумдад байгуулах, шинэ суурьшлын бүсийн дэд бүтцийг шийдвэрлэж, хөнгөлөлттэй зээлд хамруулан, эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй нийтийн болон амины орон сууцаар иргэдийг хангана.
- 1.3.2 Үндэсний баялгийн сан, нийгмийн даатгалын сангаар дамжуулан түрээслэх, түрээслээд өмчлөх орон сууцны "Түрээсийн орон сууц", цалин хөлс, орлогод нь нийцсэн төлбөрийн уян хатан нөхцөл бүхий Төрийн албан хаагчдад зориулсан орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.3.3 Гэр хорооллын "Дахин төлөвлөлт"-ийг эрчимжүүлэн дэд бүтэц, шугам сүлжээний хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- 1.3.4 "Сумдын шинэчлэл хөдөөгийн хөгжил төсөл"-ийн хүрээнд Бигэр, Тонхил сумын 120 айлын орон сууцыг барьж дуусгана.

- 1.3.5 Солонго хорооллын дэд бүтцийг түшиглэн хямд өртөг бүхий 1000-1500 айлын нийтийн орон сууцыг барьж дуусгана.
- 1.3.6 Аймаг, сумын төвийн 0.4 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг өргөтгөж, гэр хорооллын шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамжийн бүрэн шийдвэрлэнэ.

#### 1.4 УСАН ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН ХАНГАМЖ

- 1.4.1 Алтай хотын усан хангамжийн шугам сүлжээний бохирдол зэвийг өндөр даралтат азотын хийгээр угааж цэвэрлэнэ.
- 1.4.2 Алтай хотын цэвэрлэх байгууламжийг өргөтгөж, сумдын төвийг усан хангамж, ариутгах татуургын нэгдсэн шугам сүлжээнд холбож, бага оврын цэвэрлэх байгууламжтай болгох ажлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
- 1.4.3 Сумдын төвийн айл өрх, аж ахуйн нэгж байгууллагыг төвлөрсөн цэвэр ус, цэвэрлэх байгууламжид холбож, нийтийн орон сууцанд халуун усны хэрэглээг бий болгоно.

#### ХОЁР ХҮРТЭЭМЖТЭЙ АЛТАЙ

#### 2.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

- 2.1.1 Эрүүл мэндийн үзлэг, эрт илрүүлийг оновчтой, эрсдэлд суурилсан байдлаар тасралтгүй үргэлжлүүлнэ.
- 2.1.2 Бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл зан үйл, амьдралын зөв дадал, хэвшлийг сайжруулах, зөв хооллох, өвчнөөс урьдчилан сэргийлэх, хиймэл оюун ухаанд суурилсан системийг хөгжүүлж, "Цахим эмнэлэг" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.1.3 Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, байгалийн давагдашгүй хүндрэлийн үеийн эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг сайжруулна.
- 2.1.4 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, оношилгоо эмчилгээний нэгжүүдийг өргөтгөн, нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлнэ.
- 2.1.5 Яаралтай тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, "Нисдэг тэрэг"-ээр яаралтай тусламжийн үйлчилгээг үзүүлэх сумдын эмнэлгүүдийн парк шинэчлэлтийг хийж, эмчилгээ оношилгооны тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлнэ.
- 2.1.6 Эрүүл мэндийн салбарын ажилчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах, гадаад дотоодод бэлтгэх, нийгмийн баталгааг хангах "Тогтвортой ажилтан" хөтөлбөр хэрэгжүүлнэ.



## 2.2 СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮРТЭЭМЖ

- 2.2.1 Цэцэрлэгийн хоол болон ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын үдийн хоолны стандартыг шинэчлэн, орц, найрлагыг нэмэгдүүлж, амин дэмээр баялаг хоол, сүүн бүтээгдэхүүнээр үйлчилнэ.
- 2.2.2 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт эрүүл мэндийн боловсрол олгох хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.2.3 Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд сурагчдын бие даан суралцах чадварыг нэмэгдүүлэн эрчимжүүлсэн, төрөлжсөн, гүнзгийрүүлсэн сургалтыг зохион байгуулан, сурагчдын элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст оноог (512) ахиулан улсын хэмжээнд эхний таван байранд багтаана.
- 2.2.4 “Чадварлаг багш” арга хэмжээний хүрээнд багш нарын мэргэжлийн мэдлэг, ур чадвар, мэргэжлийн багшийн хангалтыг нэмэгдүүлэн нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.
- 2.2.5 Нүхэн жорлонтой бүх сургууль, цэцэрлэг, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.
- 2.2.6 Сурагчдын авьяас чадвар, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлж, хичээлээс гадуурх сонгон, дугуйлангийн үйл ажиллагааг өргөжүүлэн “Хүүхдээ сонсьё” аяныг хэрэгжүүлнэ.
- 2.2.7 Сургуулиудын номын санг шинэчилж, бүх сургуулиудад лаборатори, зарим сургуулиудад туршилтын талбай шинээр байгуулна.
- 2.2.8 Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний их сургуулийн салбар Анагаах Ухааны сургуулийг бүсийн хөгжлийн сургалт, оношилгоо, судалгаа шинжилгээний төв болгоно.

## 2.3 НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХҮРТЭЭМЖ

### 2.3.1 ХҮҮХЭД

- 2.3.1.1 Хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулж, сум бүрийг гэр бүл, хүүхэд хөгжил хамгааллын нийгмийн ажилтантай болгоно.
- 2.3.1.2 Сургуулийн боловсролын хөтөлбөрт эрүүл мэнд, хог хаягдал, байгаль орчин, ажил мэргэжлийн талаар салбарын мэргэжлийн хичээлийг нэвтрүүлнэ.
- 2.3.1.3 Аймгийн төвийн соёл амралтын хүрээлэнг өргөтгөн Мазаалай цогцолборыг байгуулж, сумдад хүүхдийн тоглоомын талбайг байгуулан арчилгаа, үйлчилгээ, аюулгүй байдлыг төр, хувийн хэвшил, оршин суугчдын оролцоотойгоор хангуулна.

### 2.3.2 ОЮУТАН ЗАЛУУЧУУД

- 2.3.2.1 Залуучуудын гарааны бизнес эрхлэх, нөхцөлийг нэмэгдүүлэн аймгийн төвд бизнес инкубатор төвийг байгуулна.
- 2.3.2.2 Залуучууд, залуу гэр бүлийг орлогод нийцсэн уян хатан төлбөрийн нөхцөлтэй орон сууц худалдан авахад дэмжлэг үзүүлнэ.

- 2.3.2.3 Анагаахын Шинжлэх Ухааны Их сургуулийн аймаг дахь салбар сургууль болон МСҮТ-ийн оюутан сурагчдыг сургалт, үйлдвэрлэлийн дадлага, хэлний бэлтгэлд Улаанбаатар хот, гадаад улсад хамруулна.
- 2.3.2.4 Хүүхэд залуучуудын хэрэгцээ шаардлагад суурилсан сурч боловсрох, хөгжих, соёл хүмүүжил, нийгмийн хөгжлийг дэмжсэн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.3.2.5 Нэн шаардлагатай мэргэжлээр суралцаж буй оюутанд зориулж орон нутгийн тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэн, ажлын байр орон сууцаар хангана.

### 2.3.3 ГЭР БҮЛ

- 2.3.3.1 Идэвхтэй бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлэх бодлогын хүрээнд гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжиж дундаж давхаргыг тэлнэ.
- 2.3.3.2 Ганц бие өрх, өрх толгойлсон эцэг (эх)-т ээлтэй тогтолцоог хөгжүүлнэ.
- 2.3.3.3 Хувь хүн, гэр бүлтэй ажиллах нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийг тогтмол ажиллуулна.

### 2.3.4 АХМАД НАСТАН

- 2.3.4.1 Ахмадуудад төрөлжсөн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, идэвхтэй насжилтыг дэмжинэ.
- 2.3.4.2 Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр сайн туршлага, санал санаачилгыг дэмжиж ажиллана.

### 2.3.5 МАЛЧИД

- 2.3.5.1 Таван их наяд хөтөлбөрийн хүрээнд малчдын орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 2.3.5.2 Зудад өртсөн малчдын эрсдлийн үнэлгээнд үндэслэн хөтөлбөр боловсруулж, "Өвөлжөө" төслийг хэрэгжүүлнэ.
- 2.3.5.3 Малчдын боловсрол, эрүүл мэнд, нийгэм соёлын үйлчилгээг "Шинэ хоршоо" хөдөлгөөнөөр дамжуулан шинэ түвшинд хүргэнэ.

### 2.3.6 ЭХЧҮҮД, ЭМЭГТЭЙЧҮҮД

- 2.3.6.1 Жендерийн тэгш байдлыг хангах, хүний эрхийн боловсрол олгох арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 2.3.6.2 "Цалинтай эх, эцэг" нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлнэ.

### 2.3.7 ЭРЭГТЭЙЧҮҮД

- 2.3.7.1 Идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлэх бодлогын хүрээнд "Аав, эрчүүд", "Чанартай амьдрал-Аавуудын оролцоо" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.3.7.2 Эрэгтэйчүүдийн дундаж насжилтыг нэмэгдүүлэх нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

### 2.3.8 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

- 2.3.8.1 Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу бүс, аймгийн эдийн засгийн баталгааг хангах мега төсөлд хамрагдана.



- 2.3.8.2 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон байнгын ажлын байрны тоогоор санхүүждэг тогтолцоог хэрэгжүүлнэ.
- 2.3.8.3 Төсөв, мөнгөний бодлогын оновчтой хослолоор эдийн засгийн сэргэлт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлэн, амьдралын чанарыг сайжруулна.
- 2.3.8.4 Өрхийн болон бичил, жижиг, дунд, бизнес эрхлэгчдийг дэмжин, татварын хөнгөлөлт эдлэх, шаталсан татварт хамрагдах боломжийг бүрдүүлнэ.
- 2.3.8.5 Төрийн албан хаагчдын ажлын үр дүнг үнэлэх гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоог нэвтрүүлж, цалин, хөлсийг нэмэгдүүлэн нийгмийн баталгааг хангаж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангана.
- 2.3.8.6 Шинээр ажлын байр бий болгож тогтвортой хадгалсан жижиг дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйн нэгжийг дэмжиж ажиллана.

## 2.4 АВТО ЗАМЫН ХҮРТЭЭМЖ

- 2.4.1 Босоо тэнхлэгийн Алтай -Бургастайн чиглэлийн 272 км, Алтай-Улиастай чиглэлийн 194 км хатуу хучилттай авто замыг барина.
- 2.4.2 Дэлгэр, Шарга, Хөхморьт, Баян-Уул, Дарви, Бигэр зэрэг сумдыг аймгийн төвтэй хатуу хучилттай авто замаар холбоно.
- 2.4.3 Баруун бүсийн босоо төмөр зам Говь-Алтай аймгийн Чандмань, Дэлгэр сумаар дамжин Мянганы замтай холбогдох 150 км-ийн төмөр зам барина.
- 2.4.4 Алтай хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу хотын төвд шинээр баригдах 26км-ийн урттай ус зайлуулах байгууламж бүхий хатуу хучилттай авто замын үлдсэн 22км-ийн замын ажлыг бүрэн дуусгаж ашиглалтад оруулна.
- 2.4.5 Алтай хотод зорчигч тээврийн авто үйлчилгээний төвийн барилгыг барьж тээврийн үйлчилгээг сайжруулна.

## ГУРАВ. НОГООН АЛТАЙ

### 3.1 ХҮНСНИЙ ХАНГАМЖ, ЧАНАР АЮУЛГҮЙ БАЙДАЛ

- 3.1.1 Хүнсний хувьсгал, Бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж иргэдийг хямд чанартай, эрүүл, аюулгүй, дотоодын хүнсний бүтээгдэхүүнээр хангана.
- 3.1.2 Мах, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийг хөгжүүлнэ.
- 3.1.3 Эрчимжсэн аж ахуй эрхлэх, малын тэжээл тариалах, хөдөө аж ахуйг төрөлжүүлсэн кластер хэлбэрээр хөгжүүлэхэд хувийн хэвшлийн оролцоог хангана.
- 3.1.4 Газар тариалан, жимс, жимсгэнэ, хүнсний нарийн ногооны төслийг хэрэгжүүлнэ.
- 3.1.5 Атрын дөрөв дэх аяны хүрээнд газар тариалан, хүлэмжийн аж ахуй, усалгааны системийг хөгжүүлэн, жимс жимсгэнэ хүнсний ногооны нэр төрлийг нэмэгдүүлэн хүнсний хангамжийг сайжруулна.

### 3.2 ТОХИЖИЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖ

- 3.2.1 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратеги төлөвлөгөөтэй уялдуулан нэг хүнд ногдох ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

- 3.2.2 Айл өрх хашаандаа мод тарих ногоон байгууламж байгуулах ажлыг дэмжиж, мод ургуулах, арчлан хамгаалах сургалтын зохион байгуулна.
- 3.2.3 Алтай хотын зам талбай, орон сууцны гэрэлтүүлэг, камерыг 2 дахин нэмэгдүүлж, гэр хорооллын гудамжны гэрэлтүүлгийг сэргээгдэх эрчим хүчтэй холбогдсон хэмнэлттэй ухаалаг системээр үе шаттай шинэчилнэ.
- 3.2.4 Орон сууц, гэр хорооллын бүсэд ногоон орчин бий болгон тохижуулах ажлыг төр, хувийн хэвшил, иргэдийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
- 3.2.5 Алтай хотын төв, сумдад 20 хүртэлх км-ийн урттай явган болон дугуйн зам барина.

### 3.3 АГААР, ХӨРС, УСНЫ БОХИРДОЛ

- 3.3.1 Алтай хот, сумдын хуучин хог хаягдлын цэгийг технологийн дагуу хөрсөөр хучиж, мод тарьж зүлэгжүүлнэ.
- 3.3.2 Аймгийн төвийн агаар, хөрс, усны бохирдлын эх үүсвэр болсон гэр хорооллын нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжтай болгох ажлыг хэрэгжүүлнэ.
- 3.3.3 Нийтийн орон сууцны барилгын гадна фасадыг шинэчлэх, дулаан алдагдлыг бууруулах ажлыг улс, орон нутгийн төсөв, гадаадын төсөл, хөтөлбөр, хувийн хэвшил, СӨХ, иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.

### 3.4 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

- 3.4.1 Хувийн хэвшилд суурилсан хог хаягдлын менежментийн багийг бүрдүүлнэ.
- 3.4.2 Алтай хот, сумдын гудамж талбайн цэвэрлэгээ, хог ачиж, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд тусгай зориулалтын тоног төхөөрөмж бүхий машин техник хэрэгслийг нэвтрүүлнэ.

## ДӨРӨВ. ОРЛОГОТОЙ АЛТАЙ

### 4.1 ШИНЭ ХОРШОО ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТ

- 4.1.1 Шинэ хоршоо хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд өрнүүлж, хамтын хариуцлагын хөнгөлөлттэй зээл олгох хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.
- 4.1.2 Хоршоололд суурилсан хагас эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, худаг гаргах, ногоон тэжээл тариалах, тоног төхөөрөмж худалдан авах хөрөнгө оруулалтыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 4.1.3 Малчдад өвөлжөө хаваржааны газрыг урт хугацаатай эзэмших, ашиглах, тэжээлийн ургамал тарих газрын байршил хэмжээг аймаг, сумын газар зохион байгуулалтын жил бүрийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

### 4.2 ХУВИЙН ХЭВШЛИЙГ ДЭМЖИНЭ

- 4.2.1 Орон нутгийн үйлдвэр үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр, логистикийн цогцолборын байршлыг тогтоож, хувийн хэвшил, хоршоодыг дэмжинэ.



- 4.2.2 Малчид хоршоолох замаар мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, арьс, шир, боловсруулах болон ноос, ноолууран эдлэл, оёмол, нэхмэл, сүлжмэлийн үйлдвэр, цех байгуулан ажлын байрыг сум бүрд нэмэгдүүлнэ.
- 4.2.3 Улс, орон нутгийн төсөв, орон нутаг хөгжүүлэх сан, гадаад, дотоодын төсөл хөтөлбөрт хамрагдах бодлогыг өргөжүүлэн, татварын бааз суурийг өргөтгөн эдийн засгийн бие даах чадварыг бий болгоно.
- 4.2.4 Үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг арилгаж, иргэдийн бизнес эрхлэх орчныг сайжруулан зөвшөөрлийн тогтолцооноос стандарт хангасан тогтолцоонд шилжих бодлогыг хэрэгжүүлнэ.
- 4.2.5 Алтай хотын цахилгаан эрчим хүчний цагийн ялгавартай тарифыг хэрэгжүүлж, өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх нөхцлийг хангана.

#### 4.3 ӨМЧИЙН ЗӨВ МЕНЕЖМЕНТ

- 4.3.1 Хөрөнгийн зах зээлийг хөрөнгө оруулалтыг татдаг суурь болгон хөгжүүлж, Алтай хотын хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээ, хөтөлбөрийг санхүүжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 4.3.2 Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот аж ахуйн нэгжүүдийг нээлттэй, олон нийтийн хяналттай "Шилэн" үйлдвэрийн газар болгоно.

#### 4.4 СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧДАЛ

- 4.4.1 Үндэсний өв уламжлал, түүх, уран зохиол, нүүдлийн ахуйн соёлыг шингээсэн хөтөлбөр, уран бүтээл, дижитал контент бүтээгчдийг дэмжиж, соёлын боловсролтой, эерэг хандлагатай бүтээлч иргэдийг төлөвшүүлэх "Бүх нийтийн соёлын боловсрол-II" арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 4.4.2 Монгол Улсын соёл, урлагийн мэргэжлийн байгууллагуудтай Ардын дуу бүжгийн Алтай чуулгын уран бүтээлчид, хүүхэд залуучууд, ардын авьяастнуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, мэргэжил ур чадвар, хүний нөөцийн хангамжийг дээшлүүлэн, шинэ уран бүтээлийн тоог нэмэгдүүлнэ.
- 4.4.3 Нийтийн хөдөлгөөн, спортоор хичээллэгсдийн нөхцөлийг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 4.4.4 Ерөнхий боловсролын сургуулиудын шаардлага хангаагүй спорт заалны стандартад нийцүүлэн шинэчилнэ.
- 4.4.5 Олон улс, хотуудын түвшинд аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг, тамирчдын бэлтгэл, тэмцээний санхүүжилтийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр шийдвэрлэн, тэдний үзүүлэх амжилтыг дээшлүүлнэ.
- 4.4.6 Орон нутгийн онцлог тохирсон аялал жуулчлалын брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгон, аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн ур чадварыг сайжруулж, жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

### ТАВ. АЮУЛГҮЙ АЛТАЙ

#### 5.1 ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ОНОВЧТОЙ ТӨЛӨВЛӨЛТ

- 5.1.1 Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зөв зохистой ашиглах, хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг



- бүрдүүлж, усан хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, усны чанар, аюулгүй байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлнэ.
- 5.1.2 Уул уурхайн лиценз олголтыг олон нийтэд нээлттэй ил тод болгож, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгоно.
- 5.1.3 Нөхөн сэргээлтийн хяналтыг сайжруулж, газрын доройтлыг бууруулан, гол, нуур, булаг шандын эхийг хамгаалж, гүний усны нөөц ашиглалтыг хязгаарлах бодлого баримтална.
- 5.1.4 Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтанд авах эко системийн чухал ач холбогдол бүхий газар нутгийн байршил, тоо хэмжээг нэмэгдүүлж төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар хэрэгжүүлнэ.
- 5.1.5 Байгаль орчин, уур амьсгалын сөрөг үр нөлөөг бууруулах зорилтын хүрээнд хөв цөөрөм байгуулах, булаг шандын эхийг хашиж хамгаалах, Загийн ойн сан бүхий сумдад Загийн ой тарьж ургуулан, байгалийн сэргэн ургалтыг дэмжих замаар ой, ойн зурвасыг байгуулан цөлжилтөөс сэргийлнэ.

## 5.2 ИННОВАЦИ, ХИЙМЭЛ ОЮУН УХААН, ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ

- 5.2.1 Төрийн бүх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж ухаалаг "E-Mongolia" системийг нэвтрүүлэн үйлчилгээ авах хугацаа болон үе шатыг хоёр дахин бууруулна.
- 5.2.2 Сум, тосгоныг өндөр хурдны интернэтийн шилэн кабелийн сүлжээнд холбон интернэтийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 5.2.3 Сум, суурин, алслагдсан багуудыг үүрэн холбооны 3G, 4G сүлжээнд холбоно.
- 5.2.4 Цахим Алтай төслийн хүрээнд нэг цагийн нэгдсэн үйлчилгээний хүрээг өргөтгөнө.

## 5.3 ГАМШГИЙН БЭЛЭН БАЙДАЛ

- 5.3.1 Газар хөдлөлт, гал түймэр, үер, мал амьтны гоц халдварт өвчин зэрэг гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулж, гамшгийн аюулд өртсөн тохиолдолд хохирлыг богино хугацаанд арилгаж байх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 5.3.2 Гамшгийн эрсдэлийг бууруулахад иргэд, олон нийтийн оролцоо, гамшгаас хамгаалах мэдлэг ойлголтыг нэмэгдүүлнэ.
- 5.3.3 Үер усны гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэж, үерийн далан суваг, ус зайлуулах шугам сүлжээний засвар, өргөтгөл шинэчлэлийг хийж, усанд автагддаг авто зам болон явган хүний замын тоог бууруулна.
- 5.3.4 Онцгой байдлын байгууллагыг гамшгаас хамгаалах техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж, бэлэн байдлыг дээшлүүлнэ.
- 5.3.5 Олон нийтийн оролцоонд түшиглэсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулж, иргэдийн амар тайван аж төрөх нөхцөлийг хангана.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

